

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБА

Төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах тухай зар

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
 - Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
 - Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.
- Бүрдүүлэх материал:
- ✓ Төрийн албан хаагчийн анкет;
 - ✓ Иргэний үнэмлэхийн хуулбар;
 - ✓ Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
 - ✓ Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа;
 - ✓ Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
 - ✓ Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
 - ✓ Сүүлийн гурван жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
 - ✓ Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–с татан авах/.

Материал хүлээн авах:

🕒 Хугацаа: 2023 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн 14:00 цагаас 9 дүгээр сарын 15-ны өдрийн 17:00 цаг хүртэл

✉ Хүлээн авах хаяг: zaaya8609@gmail.com цахим шуудан

☎ Холбоо барих утас: 11-31 31 93 , 88091568

ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

дд	Байгууллагын нэр	Нэгжийн нэр	Албан тушаалын		Орлог	Албан тушаалд тавигдах тусгай шаардлага			Материал хүлээн авах цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар
			ангилал	нэр		Боловсрол	Мэргэжил	Туршлага	
1	Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба	Удирдлага, зохион байгуулалтын хэлтэс	ТЗ-8	Хурлын хуралдаан хариуцсан мэргэжилтэн	1	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	- эрх зүй /0421/; - менежмент ба удирдахуй /041303-041305/; - удирдлага, төрийн удирдлага, төрийн захиргаа/; - нийгмийн ажил /092301/; - эдийн засаг /0311/.	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	Цахим хаяг: zaya8609@gmail.com Холбоо барих утас: 11-31 31 93 , 88091568
2		Иргэний оролцоо, эрх зүй, мэдээлэл харилцааны хэлтэс	ТЗ-8	Мэдээллийн технологи, цахим сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	1	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	- мэдээлэл, харилцаа холбооны технологиуд /061201-061204, 0613, 0619/; - хэвлэл мэдээллийн технологи /038805/; - менежмент ба удирдахуй /041301-041303/;	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	